



ДУНДГОВЬ АЙМГИЙН  
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН ТЭРГҮҮЛЭГЧДИЙН  
ТОГТООЛ

2019 оны 12 сарын 23 өдөр

Дугаар 118

Мандаговь

Үндсэн хөрөнгө бүртгэх тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 77 дугаар зүйлийн 77.3, аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2018 оны 77 дугаар тогтоолоор батлагдсан “Орон нутгийн өмчид эд хөрөнгө олж авах, бүртгэх, данснаас хасах, шилжүүлэх журам”-ын 4 дүгээр бүлгийн 4.2 дахь хэсгийг тус тус үндэслэн аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдээс ТОГТООХ НЬ:

Нэг: Аймгийн Төв халхын дуулалт жүжгийн театрт шаардлагатай нийт 8,099,776 /найман сая ерэн есөн мянга долоон зуун далан зургаа/ төгрөгийн үнэтэй тоног төхөөрөмжийг хавсралтын дагуу бэлтгэхийг зөвшөөрсүгэй.

Хоёр: Аймгийн Төв халхын дуулалт жүжгийн театрын дарга /Д.Доржсүрэн/-д дор дурдсан арга хэмжээ авч ажиллахыг даалгасугай.

2.1. Комисс томилон хөрөнгө хүлээн авч бүртгэх ажлыг байгууллагын өмч хамгаалах Байнгын зөвлөлийн хяналт дор холбогдох хууль тогтоомжийн дагуу байгуулах;

2.2. Хөрөнгийн хөдлөлийг зохих хууль тогтоомж, журмын дагуу нягтлан бодох бүртгэл, тайланд тусган, “Төрийн болон орон нутгийн өмчийн удирдлагыг мэдээлэлжүүлэх систем”-д бүртгэх;

2.3. Энэ тогтоолын биелэлтийг 2019 оны 4 дүгээр улиралд багтаан Орон нутгийн өмчийн газарт ирүүлэх;

Гурав: Энэхүү тогтоолын хэрэгжилтэнд хяналт тавьж ажиллахыг Аймгийн Засаг дарга (О.Бат-Эрдэнэ)-д үүрэг болгосугай.

ДАРГА  С.СҮХБААТАР



Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын  
Тэргүүлэгчдийн 2019 оны 12 дугаар сарын  
23 өдрийн 118 тогтоолын нэгдүгээр хавсралт

Төв халхын дуулалт жүжгийн театрын шинээр  
бэлтгэсэн хөрөнгийн мэдээлэл

№	Хөрөнгийн нэр	Хэмжих нэгж	Тоо хэмжээ	Нэгжийн үнэ	Нийт үнэ
УИХ-ын гишүүн Б.Наранхүүгийн хандиваар					
1	Dell Gerber процессор	ш	1	1,300,000	1,300,000
2	Нөтбүүк	ш	1	1,300,000	1,300,000
3	Kenwood станц	ш	6	129,746	778,476
4	Процессор	ш	1	150,000	150,000
БСШУСЯ-ны хандиваар					
5	Цахилгаан даралтат хөгжим	ш	1	2,371,300	2,371,300
Төлөвлөгөөнөөс давсан орлогоор					
6	Олон үйлдэлт принтер	ш	1	700,000	700,000
7	Өнгөт принтер	ш	1	1,500,000	1,500,000
					8,099,776 /найман сая ерэн есөн мянга долоон зуун далан зургаа/